



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

1925

Талархал

УНТЭ-ийн Урологи-Андрологи төвийн тасгийн эмч
**Г.Ганболд, их эмч М.Эрдэнэсайхан, сувилагч
Н.Урансайхан** нартаа чин сэтгэлийн халуун талархал
илэрхийлмээр байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай
үзүүлж эелдэг найрсаг харилцаатай, ард иргэдийн
эрүүл энхийн манаанд хэзээд бэлэн зогсож байдаг
эрхэм эмч болон сувилагч нартаа цаашдын ажил
үйлсэд өндрөөс өндөр амжилт хүсэж чин сэтгэлийн
талархалаа илэрхийлмээр байна.



Хэнээс: Ц.Батбаатар

Хаанаас: Засгийн газрын
11-11 ТӨВ

Хэнд: Урологи-Андрологи төвийн
тасгийн эмч
**Г.Ганболд, их эмч
М.Эрдэнэсайхан, сувилагч
Н.Урансайхан**



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

Талархал

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн удирдлага, эмч, сувилагч, нийт ажилтан, албан хаагчдад

Миний бие танай эмнэлгээр 8 жилийн хугацаанд тогтмол тусламж, үйлчилгээ авч ирсэн бөгөөд энэ хугацаанд миний эрүүл мэнд, амь насыг авран хамгаалах үйлсэд өндөр мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хүнлэг энэрэнгүй хандлагаар ажилласан нийт хамт олонд чин сэтгэлийн гүн талархал илэрхийлье.

Өнөөдөр миний эрүүл саруул амьдарч, ажил хөдөлмөр эрхэлж буй нь танай хамт олны мэдлэг чадвар, хичээл зүтгэл, үнэтэй хувь нэмэртэй салшгүй холбоотой юм.

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн нийт хамт олонд гүнээ талархаж байгаагаа уламжилж, цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Хэнээс: Д.Өлзийтөмөр

Хаанаас: Иргэн / бичгээр/

Хэнд: Улсын Нэгдүгээр Төв
Эмнэлгийн удирдлага, эмч,
сувилагч, нийт ажилтан, албан
хаагчдад



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

1925

Талархал

УНТЭ-ийн Эрхтэн шилжүүлэх төвийн **их эмч М.Эрдэнэсайхан**, **их эмч Д.Жавхлантөгс**, **их эмч Б.Төмөрбаатар**, **их эмч Г.Ганболд**, **их эмч Д.Баян-Өндөр**, **их эмч Н.Золзаяа**, **их эмч Г.Баярбилэг** бөөрний мэс засал, эрчимт эмчилгээний тасгийн хамт олонд эмч нарын баярын мэнд хүргэж хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө хөнгөн шуурхай чин сэтгэлээсээ ажилдагт нь баярлаж талархсанаа илэрхийлж байна. Танд болон танай хамт олонд цаашдын ажилд нь өндөр амжилт амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Хэнээс: Л.Гантуяа

Хаанаас: Засгийн Газрын
11-11 төв

Хэнд: УНТЭ-ийн Эрхтэн шилжүүлэх төвийн **их эмч М.Эрдэнэсайхан**, **их эмч Д.Жавхлантөгс**, **их эмч Б.Төмөрбаатар**, **их эмч Г.Ганболд**, **их эмч Д.Баян-Өндөр**, **их эмч Н.Золзаяа**, **их эмч Г.Баярбилэг**



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

1925

Талархал

УНТЭ-ийн Нүдний тасгийн **их эмч Н.Анарсайхан**-нд чин сэтгэлийн халуун талархал илэрхийлмээр байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж эелдэг найрсаг харилцаатай, ард иргэдийн эрүүл энхийн манаанд хэзээд бэлэн зогсож байдаг эрхэм эмч болон сувилагч нартаа цаашдын ажил үйлсэд өндрөөс өндөр амжилт хүсэж чин сэтгэлийн талархалаа илэрхийлмээр байна.



Хэнээс: Гантөмөрийн гэр
бүлээс

Хаанаас: Засгийн Газрын
11-11 төв

Хэнд:
УНТЭ-ийн
Нүдний тасгийн
их эмч Н.Анарсайхан



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

1925

Талархал

УНТЭ-ийн Ерөнхий мэс заслын эмч Аззаяад талархал илэрхийлмээр байна.

Хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө хөнгөн шуурхай чин сэтгэлээсээ ажилдагт нь баярлаж талархсанаа илэрхийлж байна. Танд болон танай хамт олонд цаашдын ажилд нь өндөр амжилт амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Хэнээс: Д.Заяа

Хаанаас: Засгийн Газрын
11-11 төв

Хэнд: УНТЭ-ийн
Ерөнхий мэс заслын
эмч Аззаяа



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

1925

Талархал

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Хэрх, үе сэргээх төвийн тасгийн эрхлэгч **Н.Энхтайван болон тус тасгийн хамт олонд** үйлчлүүлэгчидтэй эелдэг, хүндэтгэлтэй харилцаж, тусламж үйлчилгээг шуурхай, зохион байгуулалттай, чин сэтгэлээсээ үзүүлж байсанд талархал илэрхийлэе.

Иргэдийн эрүүл мэндийн төлөө хариуцлагатай, мэргэжлийн түвшинд ажиллаж, үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг хэрэгжүүлж буй танай хамт олны хөдөлмөр, зүтгэлийг өндрөөр үнэлж, чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Цаашдын ажил үйлсэд тань өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Хэнээс: Б.Лхамсүрэнгийн гэр
бүл үр хүүхдүүдээс
нь

Хаанаас: Засгийн Газрын
11-11 ТӨВ

Хэнд: Хэрх, үе сэргээх төвийн
тасгийн эрхлэгч
**Н.Энхтайван болон тус
тасгийн хамт олонд**



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

1925

Талархал

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн **Зүрхний төвийн их эмч Б.Бум-Эрдэнэ** гүн талархал илэрхийлье.

Таны мэргэжлийн өндөр ур чадвар, хариуцлагатай ажил хэрэгч байдал, өвчнийг минь шуурхай бөгөөд оновчтой оношлон, шаардлагатай тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлсэнд гүнээ талархаж байна.

Мөн үйлчлүүлэгчтэй эелдэг, хүндэтгэлтэй харилцаж, ард иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө чин сэтгэлээсээ ажилладаг Таны хүнлэг сайхан сэтгэл, ёс зүй, харилцаа хандлага нь өндөр сэтгэгдэл төрүүлсэн болно.

Иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө мэдлэг чадвар, сэтгэл зүтгэлээ зориулан ажиллаж буй Танд цаашдын ажил үйлсэд өндөр амжилт, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Хэнээс: Бадамцэцэг

Хаанаас: Засгийн Газрын
11-11 төв

Хэнд: Зүрхний төвийн их эмч
Б.Бум-Эрдэнэ



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

1925

Талархал

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн **Зүрхний төвийн их эмч Б.Бум-Эрдэнэ** , **эмч Төвшинтөгсд** талархал илэрхийлье.

Эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж эелдэг найрсаг харилцаатай, ард иргэдийн эрүүл энхийн манаанд хэзээд бэлэн зогсож байдаг эрхэм эмч нартаа цаашдын ажил үйлсэд өндрөөс өндөр амжилт хүсэж чин сэтгэлийн талархалаа илэрхийлмээр байна.



Хэнээс: Бадамцэцэг

Хаанаас: Засгийн Газрын
11-11 төв

Хэнд: Зүрхний төвийн их эмч
Б.Бум-Эрдэнэ
Төвшинтөгс



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

1925

Талархал

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Зүрхний төвийн их эмч **Б.Бум-Эрдэнэ**, **Ч.Нарантуяа**, яаралтай тусламжийн их эмч **Э.Учрал** нарт талархал илэрхийлье.

Алтан гартай эмч, сувилагч болон хамт олонд нь ажлын өндөр амжилт, амьдралд нь хамгийн сайн сайхныг хүсье. Хүмүүстэй хөнгөн шуурхай үйлчилдэгт нь баярлалаа гэдгээ хэлмээр байна.

Хүний төлөө гэсэн сэтгэлтэй энэ хүмүүс ажлын өндөр амжилт амьдарлд нь хамгийн сайн сайхныг хүсье. Эмч нарын баярын мэнд хүргэе.



Хэнээс: Амьдрах ухаан нийгмийн халамжийн төвийн байнгын үйлчлүүлэгч **Б.Мандахбаяраас**.

Хаанаас: Засгийн Газрын
11-11 ТӨВ

Хэнд: Зүрхний төвийн их эмч **Б.Бум-Эрдэнэ**, **Ч.Нарантуяа**, яаралтай тусламжийн их эмч **Э.Учрал**



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

1925

Талархал

УНТЭ-ийн Цус чөмөг шилжүүлэн суулгах тасгийн эмч **Д.Булган** нь ур чадвар өндөр , харилцаа хандлага сайтай, маш сайхан үйлчилгээ үзүүлсэнд баярлаж байна. Танд цаашдын ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэж байна.



Хэнээс: Солонгомаа

Хаанаас: Засгийн Газрын
11-11 ТӨВ

Хэнд: УНТЭ-ийн Цус чөмөг
шилжүүлэн суулгах тасгийн
эмч **Д.Булган**
